



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Нутгийн удирдлагын ордон, 3 дугаар баг,
Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас: 7052 2533, Факс: (976) 7052 2530,
Цахим шуудан: zdtg@dornogovi.gov.mn,
Цахим хуудас: www.dornogovi.gov.mn

2025.12.25 № 02/1973

танай 2025.11.19 -ны № 01/652 -Т

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВД

“Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөг уламжлагчид мөнгөн шагнал олгох тухай журам”-ын дагуу Дорноговь аймгаас 2025 онд үндэсний болон олон улсын хэмжээнд соёлын биет бус өвийг хамгаалах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэх үйл хэрэгт идэвх санаачилгатай оролцсон өвлөн уламжлагч Нанзад овогтой Лантууг нэр дэвшүүлж, баримт бичгийг бүрдүүлэн хүргүүлэв.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Г.МАРТ

4425118164

СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ ӨВЛӨН
УЛАМЖЛАГЧИЙН ТОДОРХОЙЛОЛТ

НАНЗАДЫН ЛАНТУУ



Н.Лантуу нь 1938 онд Дорноговь аймгийн Сайхандулаан сумын нутаг "Алагийн уул" гэдэг газар Гомбодашийн 1-р охин болон төрж, 1950 онд аймгийн 10 жилийн сургуульд 4-р анги төгссөн. Сайхандулаан сумандаа эцэг, эхийн хамт мал маллахын зэрэгцээ сумынхаа Улаанбуланд байнга оролцон гоцлол дуулж, мандолин тоглон бүжиглэж, Ч.Ойдовын "Далан худалч" жүжгийн Тунгалаг, Дамдинсүрэн, Семирнов, "Учиртай гурван толгой" дуурийн Хоролмаа болон бусад жижиг үзэгдэл, шог гараа зэрэгт оролцон тоглодог байсаар 1959 онд аймгийн Соёлын ордонд гоцлол дуучнаар орж хөгжмийн багш Ч.Банзрагч, Цэенбадам нараар хөгжим, нот заалгаж ёочин хөгжим тоглодог болсноор хөгжимчин, дуучин, жүжигчнээр ажиллаж эхэлсэн. Улмаар 1966 онд Улсын мэргэжлийн шалгалтанд бие даан шалгуулж 1-р зэргийн жүжигчин, 1980 онд 45 хоногийн дамжаанд суралцаж хөгжимчин, жүжигчин мэргэжлээр ажиллаж, 1988 онд тэтгэврийн насанд хүрсэн боловч ажилласаар нийт Соёлын ордон, театрт 39 жил ажиллажээ.

Энэ хугацаанд Монгол ардын дуу "Юндэнгөөгөө", Ч.Банзрагч "Эхлэн цэцэглэг", Ц.Жагдал "Үрээ хээр", С.Гончигсумлаа "Дэнжийн ногоо" зэрэг 50 гаруй дуу гоцлон, хоршил цөөхүүл, хамтлагаар 200 гаруй дуу дуулав. Л.Мөрдорж "Хаврын шувуу"-г ёочингоор, Молдав ардын аялгуу "Болжморын жиргээ" ксилофоноор, С.Баатарсүх "Цэнхэр залаа"-г ятгаар зэрэг 50 шахам хөгжмийн бүтээл гоцлолоор, хоршил, цөөхүүл хамтлаг дан хөгжмийн бүтээл болон дуучдын дуу бүжгийн хөгжимд нийт 600 гаруй хөгжмийн бүтээлээр Соёлын ордон, театрын бүх тоглолтонд оролцон тоглож байв.

Соёл урлагийн ажлуудаас гадна ээж Гомбодашийн зааж өгснөөр өдгөө ховордсон оёдлын төрлүүд болох зүү ороох, шазаргана /хос зүү ороолт/, эсгий ширмэл, утас дээс хийх, томох, утсан сүлжээсүүд /наймаар, арваар, хуруугаар, гогцоогоор/, монгол үндэсний зангилаанууд /тооно туших, тугалчлах, зааны ам, гав, бүсний/ зэргээр оёж ширж, сонирхсон хэн бүхэнд зааж сургаж байна.

Мөн ээжийнхээ гууль, хулсаар хийдэг байсан аман хуурыг дууриан хулсаар хийж, аман хуурын татлагууд болох "Уулган шарын тэшээ", "Ингэ ботго нийлэх", "Хурдан морины хатираа", "Бухын урамдалт" зэргийг татаж тоглодог.

УРАН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

Дүр бүтээсэн нь:



- Ш.Цэрэн “Анхны жил” – Гажид,
- Ц.Жагдал “Нарнаас урьдхан” – Урнаа
- Д.Намдаг “Шинэ байшинд” – Мятагмаа
- Х.Цэвэлээ, Сониндумаа – Дарьхүү, Дэлгэрмаа, Зант
- Дожоодорж “Мастерийн төрсөн өдөр” – ийн Жавзан, Аюуш
- Дуламсүрэн зэрэг 49 жүжгийн 58 дүрд, тухайн үеийн хошин шог хөтөлбөрүүд, жижиг үзэгдлүүдэд орж байлаа.




Зохиож найруулсан уран бүтээл:

- “Ширээ нуурын долгио” ёочингийн гоцлол ,
- “Зогдор сугсрах жонжоо”,
- “Салхин зөөлөн сэвшээ”
- Ч.Ойдовын “Алиа Тогмид” хүүхэлдэйн жүжгийн чимэглэл хөгжим дан хөгжмийн бүтээл 4,
- МУУГЗ Л.Ухнаагийн дэглэлт “Барилгачин залуус”
- Батмужаан “Хөдөөгийн үзэсгэлэн “ зэрэг бүжгийн хөгжим 9,
- Цэрэннадмидын шүлэг “Үйлчин бүсгүй”,
- Б.Явуухулангийн шүлэг “Тал нутгийн эзэн бүсгүй”,
- М.Чулууны шүлэг “Ноён хутагт Данзанравжаа” уртын дуу
- “Талын уянга” –Т.Манцуйт
- “Барилгачин”- МУУГЗ Л.Ухнаа
- “Аргагүй амраг”- СТА Б.Батмужаан
- “Зэрэглээ”- Т.Манцуйт
- “Барилгачин залуус” –МУУГЗ Л.Ухнаа
- “Монгол бүсгүй” – Очирбат
- Нутгийн ардын үг “Янзган зээрд” бэсрэг уртын дуу 2, нийтийн дуу 59, үг аяыг бичсэн 6, дууны шүлэг бичсэн 15 бүгд 80 дуу зохиосон байна.

“Бүрдэнэ Хайрханы залбирал” дууны шүлэг бичиж Монголын хөгжмийн зохиолчдын эвлэлийн шагналт Б.Мөнгөн-Өлзий хөгжмийг зохиож, Х.Баярсайханы зохиомж зураглалаар клип хийж олны хүртээл болгосон байна. Монгол ардын дуу Алгирмаа, Аа жимсээ хоршил, Монгол ардын дуу “Алаг морь” 4 хоолой дан найрал зэрэг хориод дуунууд, Дангаагийн дэглэлт “Үерхэл” бүжгийн зэрэг есөн бүжгийн хөгжим, “Гайхамшигт хайрцаг” үлгэрийн жүжгийн чимэглэл зэрэг таван дан хөгжмийн бүтээл, Доржготов “Байлдагчийн сэтгэл” зэрэг бүжиг,дуу, хөгжмүүдэд найруулга хийж тоглолтонд оруулав.

Уран бүтээлийн гэрэл зургуудаас:





Гадаад дотоодын томхон тоглолтууд:

1. Монголын Залуучууд оюутны урлаг, спортын их наадмууд, II их наадам 1963 онд Өмнөговьд, III их наадам 1975 онд Хэнтийд
2. "Алтанговь" аймаг сурталчлах 7 хоног 1970 онд Сэлэнгэд
3. Аймгийн Соёл урлагийн 10 хоног 1979 онд Улаанбаатарт
4. Хөдөөгийн театруудын уулзалт тоглолт 1981 онд Дарханд
5. Олон улсын урлагийн VI их наадам 1981 онд Бүгд Найрамдах Чехословак улсад
6. "Алтан намар -85" 1985 онд Улаанбаатарт
7. Бүх ард түмний ардын урлагийн Их наадам 2001 онд Улаанбаатарт
8. Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойд 2006 онд Улаанбаатарт уртын дуучнаар
9. "Олон улсын ахмадын урлагийн Их наадам" 2006 онд Улаанбаатарт
10. Халх голын ялалтын 66 жилийн ойн тоглолтонд УБТЗ-ын "Ган зам" ахмадын чуулгад хөгжимчин, уртын дуучнаар, 2011 онд Красноярск, Новосибирск, Иркутск, Улан-Уд дөрвөн хотоор явж тоглолт хийсэн.

Радио , хэвлэл мэдээлэлд:

1964, 1975, 1979 онуудад Монголын радиод Соёлын ордны уран бүтээлийн бүтэн бичлэгүүд,
1993 онд Зан үйлийн нэвтрүүлгийн редакцийн эрхлэгч Мандах "Хутагтын дуунууд", "Хутагтын аялгуут мааниуд" сургаал зэргээр бие даасан бүтэн хэмжээний нэвтрүүлэг,
1995 онд Хөгжимт жүжгийн театрын уран бүтээлээр бүрэн хэмжээний бичлэг хийж, үүнд Цэрэннадмидын шүлэг "Үйлчин бүсгүй" дуучин Сайнхүү, нутгийн ардын үг "Хаврын шинж" дуучин Санзайжамц, өөрийн үг ая "Сэвшээ салхины шивнээн" эмэгтэйчүүдийн чуулгаар гурван дуу дуулж "Ширээ нуурын долгио" ёочингийн гоцлол тоглож радиогийн алтан санд оруулсан.
1968 онд Соёлын ордны найруулагч Доржгочоо "Авьяас" найруулал
1979 онд Чойдорж "Гучин чавхдасны эгшиглээ" зэрэг Ялалт, Утга зохиол , "Хөдөлмөр" сонинуудад нийтлэлүүд,
Д.Пүрэвсүрэнгийн "Амьд бурхадын алтан сургааль" , "Тал нутгийн дуу" дууны ном зэрэгт бичигдэж байв.

Өвлүүлэн уламжлуулсан нь:

1963 оноос Улаанбадрах, Даланжаргалан зэрэг 9 сум, аймгийн төв хөдөөгийн 20 гаруй албан байгууллагуудад урлагийн үзлэг, уралдаант тоглолтуудад хөгжим дууны 40-өөд хувьд нь бичлэг хийж концерт найруулан УБТЗ-ын IV анги, ХБУГазар, 8 жилийн сургуулийн багш нарын тоглолтууд I байранд орж байлаа. 1972 онд сурагчдын дунд мандолинд 6, ятганд 8, ёочинд 4 дугуйлан хичээллүүлж, 1979 онд Мандах суманд Сумьяа, Эрдэнэтогтох нарын 4 хүнд ятга, аймагт Живаа, Ухнаа нарын 3 хүнд ёочин заасан нь одоо хүртэл мэргэжлээрээ ажиллаж байна. Мөн Тогтохжаргал, Ариунцагаан, Ариунаа зэрэг арваад хүнд ёочин хөгжим зааж сургасан нь одоо Ч.Ариунцагаан ЕБ-ын 1-р сургуульд хөгжмийн багшаар, Тогтохжаргал 2 удаа "Яргуй" наадамд хүрэл медаль авч, ардын авьяастнуудын тоглолтонд оролцсоор байна. 2013 онд Алтанширээ суманд 11 хүүхдэд уртын дуу, "Хөөрхөн халиун", "Хүрэн толгойн сүүдэр" 7 хүүхдэд ёочин, ятга, Айраг суманд 10 хоногт 18








хүүхдэд ёочин, ятга, шанз, хуучир зааж сургажээ. Багш нарын концертыг бэлдүүлж Сайхандулаан, Сайншанд сумын II, III сургуульд урлагийн үзлэг, "Яргуй" наадмыг бэлдүүлж Сайхандулааны Баярцэцэг "Финский польк" мөнгөн медаль, 2014, 2015 онд III сургуулийн Тогтохжаргал хошой хүрэл медаль, Ундрам хошой мөнгөн медаль, хөгжмийн хамтлаг "Бранс –Унгер" бүжгээр мөнгөн медаль хүртсэн байна. Одоо ардын хөгжим, монгол ардын уртын болон богинын дуу, Ноён хутагтын бүтээлээс зааж сургасан гарын шавь 60 гаруй болсон байна. 2014 оноос аймгийн Музей сургалт судалгааны төвийн дэргэдэх "Эвийн эгшиг" уртын дууны дугуйлангийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, Ноён хутагтын зохиол бүтээлээс зааж сургах, уртын дууны наадмууд, тайлан тоглолтуудад залуу хойч үеэ үлгэрлэн дагуулж, уртын болон богинын дуу дуулах, ардын хөгжим тоглох зэргээр Дорноговь аймгийн СББӨ-ийг өвлөн уламжлагчдад монгол ахуй соёлоо өвлүүлэх үйлсэд үргэлжид зүтгэж байдаг уран бүтээлч хүн юм. 2022 оны "Нүүдэлчин Монгол" соёлын биет бус өвийн их наадамд эх хэл, аман уламжлалт илэрхийллүүд, ардын язгуур урлаг, ардын уламжлалт гар урлал, уламжлалт арга ухаан, байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, үндэсний уламжлалт баяр наадам тоглоом наадгай уриа дуудлага гэсэн 6 ай савын төрлүүдээр оролцож, монгол ардын аялгуут үлгэрийг ятга хөгжмөөр тоглон оролцсон төдийгүй СББӨ-ийг өвлүүлэн уламжлуулагч шавь сургагч багшаар оролцож, өөрөөс доош гурван үеийн шавь нартайгаа мөр зэрэгцэн бүтээлээ дэлгэсэн билээ. Тус наадмаас "Хамгийн өндөр настай шилдэг өвлөн уламжлагч" шагналыг хүртэж, гар урлалын бүтээлээрээ оролцож "Шилдэг гар урлалын үзэсгэлэн"-гээр шалгарч, багийн нийлбэр дүнгээр Дорноговь аймаг маань Гутгаар байр эзлэхэд үнэтэй хувь нэмрээ оруулсан билээ.


Уралдаан тэмцээнд:

1. 1956 онд Аймгийн II дуучин цол
2. 1960 онд Үндэсний хөгжим тоглогчдын уралдаанд аймагтаа 1-р байр ,улсад цөөхүүлээр тусгай байр
3. 1993 онд Дорнын их соён гэгээрүүлэгч Данзанравжаагийн мэндэлсний 190 жилийн ойгоор зохиогдсон "Хутагтын дууг хэн сайн дуулах вэ?", "Хэн олныг мэдэх вэ?" улсын уралдаанд Хутагтын 17 дуугаар "Хамгийн олон дуу мэдэгч"-ээр 1-р байр
4. 2005 онд аймагт зохиогдсон уртын дуу дуулаачдын уралдаанд III байр
5. "Үлэмжийн чанар" шилдэг бүтээлийн уралдаанд 3 удаа тусгай байр ("Ижийгээ жаргаахсан", "Ижий минь" дуу, өөрийн үг, Доржготовын ая "Ээж минь та үнэн")
6. 1998 онд М.Мөнхтуяагийн шүлэг "Шархан хээр морь мину" дуугаар I байр
7. 2002 онд Л.Цэнд-Аюушийн шүлэг "Сүүн хайр" дуугаар II байр
8. 2013 онд Хутагтын уртын дуу дуулаачдын улсын уралдаанд III байр
9. 2016 онд "Алтан зул" хүүхдийн дууны улсын уралдаанд Монголын хөгжмийн зохиолчдын эвлэлийн шагналт Б.Мөнгөн-Өлзийн хөгжим "Нисдэг навчхан" дууны шүлгээр тусгай байранд орж кино концертод орсон.
10. 2016 онд "Үлгэрч өвөө, эмээ" улсын уралдаанд II байр

Гавьяа шагнал:

1. Монгол улсын Засгийн газрын Хүндэт Жуух бичиг 1966 онд
2. Хөдөлмөрийн хүндэт медаль 1977 онд
3. Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон 1979 онд
4. МУСТ- ажилтан 1990 онд
5. Алдарт эхийн II одон 2012 онд шагнагдсан.
6. Монгол Улсын Гавьяат жүжигчин 2021 онд.





Монголын соёлын ажлын
"Соёлын үүшн" хэлбэрний шагнал

"Соёлын асар"
медальний үнэмлэх
№ 1463


Соёл урлагийн ашиг тус түүнээс
сурч авсан зүйлд маань бус,
түүний ачаар бид ямар хүмүүс
болж байгаад оршино.

Оскар Уайльд



2015 оны 2-р сарын 2-д
Улаанбаатар хот

Номхад
Лантуу
Монгол Улсын соёл урлагийн хөгжил
дөвшл, уламжлал, шинэчлэлд
зориусан бие сэтгэл, ирээдүйн,
хөгжмийн бүтээл, хувь нэмрийг үнэтэй
баталгаажуулж "Соёлын асар"
медальонгоор шагнагдан.

Монголын соёлын ажлын
"Соёл үүшн" хэлбэрний
Түгээгч захирал, Доктор
Г.Баттар



Оноо... Номхад
Лантуу
Нэр... Лантуу
Монгол Улсын Ерөнхийлөгчийн
2015 оны 05-р сарын 02-ны
артайн дүгээр зарлигаар
"АЛДАРТ ЭХ" 2 дугаар
оноогоор шагнасан
Монгол Улсын
Ерөнхийлөгч
Ц.Элбэгдорж
ЦАХНАГИЙН ЭЛБЭГДОРЖ






Түгээн дэлгэрүүлсэн нь:

1959 оноос цуглуулсан 1000 шахам ардын дуунаас зөвхөн нутгийн ардын 63 дуутай "Говь нутгийн түрлэг" дууны ном, 2007 онд,





Орон нутагт голчлон уншигддаг болон Хутагтын зохиосон аялгуут маани 16 уран бүтээлчдийн болон Бурханы сэдэвтэй дуу 17, бүгд 33 бүтээлтэй "Буяны буман цацраг" ном 2011 онд,

Монгол ардын харилцаа 46 дуутай, М.А.Харилцаа дууны ном 2019 онд,

"Буяны буман цацраг" номыг дахин шинэчлэн 2020 онд тус тус хэвлүүлсэн.



Мартагдсан оёдол, уран зангилаа хийж буй гэрэл зургууд:



“ЯЗГУУР АЛТАН ӨВ” ДОРНОГОВЬ АЙМГИЙН СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН АНХДУГААР НААДАМД

Дорноговь аймгийн хэмжээнд анх удаа соёлын биет бус өвийн наадмыг амжилттай зохион байгуулж, 14 сумын хэмжээнд өвлөн уламжлагчдыг тодруулж, ай сав бүрээс шилдгүүдийг шалгаруулсан. Тус наадамд Н.Лантуу нь өөрийн шавь нарын хамт амжилттай оролцож, “Дорноговь аймгийн Шилдэг 10 өвлөн уламжлагч”-ийн нэгээр шалгарсан.



“НҮҮДЭЛЧИН МОНГОЛ-2022” СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ИХ НААДАМД

“Нүүдэлчин Монгол” наадамд 6 ай савын төрлүүдээр бэлтгэж, монгол ардын аялгуут үлгэрийг ятга хөгжмөөр аялгуулан хэлж амжилттай оролцсон. Өөрөөс доош гурван үеийн шавь нарын хамт ардын уламжлалт гар урлалын ай савд бүтээлээ дэглэн тавьж, “Шилдэг гар урлалын үзэсгэлэн”-гээр шалгарсан. Мөн “Нүүдэлчин Монгол” наадмын “Хамгийн өндөр настай шилдэг өвлөн уламжлагч”-аар шалгарсан.



“НҮҮДЭЛЧИН МОНГОЛ-2024” СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ИХ НААДАМД

“Нүүдэлчин Монгол” наадамд 6 ай савын төрлүүдээр бэлтгэж, монгол ардын аялгуут үлгэрийг ятга хөгжмөөр аялгуулан хэлж амжилттай оролцсон.

ӨВЛӨН УЛАМЖЛАГЧДЫН ТОГЛОЛТ

Орчин цагийн музей үүсч хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд Музей сургалт судалгааны төвөөс сарын аян зарласан. Уг аяны хүрээнд Дорноговь аймгийн өвлөн

уламжлагчдын нэгдсэн тоглолтыг зохион байгуулж үүнд Ардын үлгэр домог, ятга хөгжмийн өвийг сурталчлан тоглож амжилттай оролцсон.



2023.03.03

Сайншанд хотынхоо дунд сургуулийн хүүхдүүдэд зориулж сургууль дээр нь очин үндэсний язгуур өв соёл аман уламжлалаас тууль, аялгуут домог, аялгуут үлгэр, ерөөл, магтаал, уртын дуу, аялгуут маань, аялгуут сургаал зэргийг тайлбарлаж сонирхуулан тоглосон. (Ерөөлч магтаалч Хуягбаатарын Данзанравжаа-н хамт)

Ая зохиосон дуунууд:

1. "Хаврын говь" – Ядамсүрэн
2. "Үйлчин бүсгүй"-Цэрэннадмид
3. "Тал нутгийн эзэн бүсгүй"- Явуухулан
4. "Хаврын шинж"- нутгийн ардын үг
5. Эрдмийн эх
6. "Хонгор галуу ганга" аялгуу Цэрэннадмид
7. "Тахилгат хайрхан"- Цэрэннадмид, Жагдал найрал дуу
8. "Ээж минь та үнэн" - Доржготов - Үлэмжийн чанарт тусгай байр
9. "Ижий нутаг хоёр"- Л.Эрдэнэбат
10. "Алаг нүдэн Мядагмаа"- Со.Чулуу
11. "Шархан хээр морь мину"- Мөнхтуяа -Үлэмжийн чанарт I байр
12. "Чандмань хайрхан"- М.Чулуу
13. "Ноён хутагт Данзанравжаа" айзам уртын дуу- М.Чулуу
14. "Өмгөөлөгч та"-М.Чулуу
15. "Бодлын цагаан реки"- Халзан
16. "Магнайн баяр хүлгүүд"- Өлзийбат
17. "Аньсага зөөлөн ижий"- М.Чулуу
18. "Ангир шарга"-Х.Болдбаатар
19. Кабын сүлд дуу
20. "Сүүн хайр"- А.Цэнд-Аюуш Үлэмжийн чанар II байр
21. "Сүлдэн ижий"-Цэдэвдорж
22. "Халзан уулын рашааны дуу"- Цэдэвдорж
23. "Амирлангуй хөх уул"-Х.Сүглэгмаа
24. "Үд дундын говь"-Халзан

25. "Халагдах цэргийн дуу" - М.Чулуун
26. "Амрагийн дуу" - Ч.Баасанжав
27. "Үйл заяа хоёр" - Халзан
28. "Бишрэн сүсэглэе" - Ч.Баасанжав
29. "Энхамгалангийн ерөөл" - Ч.Баасанжав
30. "Бүтээлийн цагаан сүм" - Содномдорж
31. "Авгын цагаан уул" - М.Чулуун
32. "Одсэргочоо шүтээний мөргөл" - Д.Норов
33. "Өргөл эгшиг" - Г.Цагаандэрэм
34. "Адуучны хийморь" - Ч.Баасанжав
35. "Ижий тандаа" - Ч.Баасанжав
36. "Дурсамжийн дуу" - Бямбадулам
37. "Хайрын цагаан шөнө" - Содномдорж
38. "Хүлэг минь" - Ч.Баасанжав
39. "Хамтдаа буцахгүй хань" - Ч.Төмөртоогоо
40. "Янзган зээрд" нутгийн ардын үг бэсрэг уртын дуу
41. "Чамайгаа үгүйлнэ" - Ч.Баасанжав
42. "Тойн багштан" - Ч.Баасанжав
43. "Тэмээчин заяа" - М.Чулуун
44. "Багшаа хүндлээрэй" - Нямдорж
45. "Алаг зүрхний дуулал" - М.Чулуун
46. "Налгар буурал ээж" - М.Чулуун
47. "Энхсаран сувиллын дуу" — Д.Буян-Амгалан
48. "Зүрхний гэгээн анир" - Ч.Баасанжав
49. "Нутгаа санасан сэтгэл" - М.Чулуун
50. "Жаргалын өргөө" - Цээсэд
51. "Сэрүүн зүүдний амраг" - Баасанжав
52. "Хөх л борогтой тал" - Баасанжав
53. "Дарь эхийн магтаал"
54. "Хутагт багшдаа" - Жадамбаа
55. "Алтганы тал" - Эрдэнэдалай
56. "Жимсчдийн алдар" - Баасанжав
57. "Өндөр тэнгэрийн үүд" - Д.Цээсэд
58. "Юухан бэ" - Б.Төмөрпүрэв
59. "Аргамаг шарга" - Ч.Баасанжав

Дууны шүлгийг нь зохиосон:

1. "Үрдээ мөнх аав" - Б.Ганболдын ая
2. "Ижий тандаа мөргөмүй" - Б.Ганболд
3. "Нутгийн цэнхэр аялгуу" - М.Сүрэнжав
4. "Сулинхээрийн намар" - МУУГЗ А.Эрдэнэ-Очир
5. "Духандаа тоосгүй хүлгүүд" - Б.Ганболд
6. "Бүрдэнэ хайрханы залбирал" - МХЗЭ-ийн шагналт Б. Мөнгөн-Өлзий
7. "Бонго найз" - Б. Мөнгөн-Өлзий
8. "Ачтаны манлай Хутагт мину" - Б.Мөнгөн-Өлзий
9. "Эрдэнийн говь" - Х.Болдбаатар

10. “Эмч бурхан”-Б.Мөнгөн-Өлзий
11. “Өлгийн хийдийн магтаал дуу”- Б.Мөнгөн-Өлзий
12. “Ятгахан чи минь”- С.Тунгалаг
13. “Хөдөөгийн сайхан айл”- Б. Мөнгөн-Өлзий
14. “Нисдэг навчхан”- Б.Мөнгөн-Өлзий “Алтан зул “ улсын уралдаанд тусгай байр.
- 15.”Өнөрчүүдийн бүл”- Ж.Нямсүрэн

ӨВЛӨН УЛАМЖЛАГЧИЙН МАТЕРИАЛЫГ БЭЛТГЭСЭН:
ДОРНОГОВЬ АЙМГИЙН МУЗЕЙ СУРГАЛТ СУДАЛГААНЫ ТӨВИЙН
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТАН: **Б.ЦЭНДБАЯР**



МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХ
CITIZEN IDENTITY CARD OF MONGOLIA



Овог Family name
Боржигон
Эцэг /эх/-ийн нэр Surname
Нанзад
Nanzad
Нэр Given name
ЛАНТУУ
LANTUU
Хүйс Sex
Эмэгтэй /Female
Төрсөн он, сар, өдөр
Date of birth
1938/02/17

Регистрийн дугаар Registration number
E938021769 / YeE38021769



Олгосон байгууллага Issuing authority
Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар
The General Authority for State Registration



Олгосон он, сар, өдөр Date of issue
2012/11/03
Хүчинтэй хугацаа Date of expiry
0000/00/00
Хаяг Address
Дорноговь, Сайншанд
1-р баг, дэмпил гудамж
13-17 тоот



MNG





ДОРНОГОВЬ АЙМАГ
САЙНШАНД СУМЫН
6 ДУГААР БАГИЙН ЗАСАГ ДАРГА

2-214 тоот байр, Шинэ зууны гудамж, 6 дугаар баг,
Сайншанд сум, Дорноговь аймаг, 44102
Утас: (976) 7052 2636

2022.12.19 № 01/759

танай _____-ны № _____-т

СОЁЛИЙН ӨВИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВД

Нанзадын Лантуу /ЕЭ38021769/ нь тус багийн
С.Дампилын 12 дугаар гудамжны 1201 тоотод
оршин суудаг нь болохыг тодорхойлов.



Э.УРАНЧИМЭГ

2025 ОНД ХИЙСЭН АЖИЛ, АМЖИЛТУУД:

- Говьсүмбэр аймагт зохион байгуулагдсан говийн бүсийн 4 аймгийн ахмадын урлаг, спортын наадамд оролцож нутгийн ардын богино дуу, магтаалын төрлүүдэд тус тус 1-р байр эзэлсэн.
- Монголын үнэдсний олон нийтийн радиод өөрийн өвлөн уламжилж сэргээсэн нутгийн ардын богино дуу, домогтой дуу, аялгуут үлгэр зэргийг бичүүлж үлдээсэн бөгөөд тус радиогын ярилцлагад оролцож баримтжуулалтыг бий болгосон
- Аймгийн "Маанийн холбоо"-ны 30 жилийн ойн бүрэн хэмжээний тоглолтыг найруулан ажиллаж тус холбооны 5 ахмадад нутгийн ардын богино дуу, магтаалыг зааж түгээн дэлгэрүүлсэн
- Аймгийн Музей сургалт судалгааны төвөөс зураглаач, аялагч Б.Батзоригтой хамтран соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын баримтжуулалт бүхий видео контентыг бэлтгэж өвлөн уламжлагч Н.Лантуу аялгуут үлгэр, аялгуут ертөнцийн гурав өвийн төрлөөр баримтжуулалтад хамрагдаж олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор бичлэгийг ZORIG Badarch youtube сувагт байршуулсан одоогоор 600 гаруй үзэлт хандалтыг авсан байна.
- МУ-ын Засгийн газрын тогтоолоор жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалд 3 удаа оролцож өөрийн эзэмшиж өвлөн уламжилсан аялгуут үлгэр, ертөнцийн 3, нутгийн ардын дууг олон нийтэд сурталчлан түгээн дэлгэрүүлсэн бөгөөд тус онд "Өндөр настай шилдэг өвлөн уламжлагч"-аар шалгарсан амжилттай оролцлоо.



